

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2010 он 01 дүгээр  
сарын 27 -ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ҮЦТТТХТ” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, илэрсэн зөрчил дутагдлын талаар Хорооны гишүүн, улсын ахлах байцаагч Д.Дүгэржав танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. “ҮЦТТТХТ” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, болон гарсан зөрчил дутагдал, мөн Ажлын хэсгээс өгөх үүрэг, Хорооны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сонсоод, “ҮЦТТТХТ” ХХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Гандулам/-д дараах ажлыг үүрэг болгохоор тогтов:

1/ Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Хорооноос болон шалгалтын Ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, биелэлтийг Хороонд тайлагнах;

2/ Ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд шуурхай тараах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж аль компанийн хэдэн оны ногдол ашиг тараагдаж буй талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж байхтай холбогдох зохицуулалтыг дотоод журамдаа оруулж цаашид мөрдөж ажиллах;

2. Хорооны 2008 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 200 дугаар тогтоол батлагдсанаас хойш шүүхийн болон Хорооны шийдвэр, гэрээ дүгнэсэн актаар хийгдсэн арилжааны бус гүйлгээнээс илүү төлөгдсөн шимтгэлийн мөнгөн хөрөнгийг хууль ёсны өмчлөгч нарт буцаан олгохыг “ҮЦТТТХТ” ХХК ТУЗ /Б.Сүхбаатар/-д үүрэг болгохоор тогтов.

3. “Жуулчин говь” ХК, “Монгол эсгий эсгий гутал” ХК, “Сонсголон бармат” ХК, “Разноимпекс” ХК-ийн Төвлөрсөн хадгаламж дахь үнэт цаасны бүртгэлийн зөрүүтэй асуудал, “ҮЦТТТХТ” ХК-ийн 99-5 дансан дахь хамтын сангийн хувьцаа болон бэлэн мөнгийг хэрхэн шийдвэрлэх талаарх саналаа Хорооны 2010 оны 02 дугаар сарын ээлжит хуралдаанд танилцуулах, тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-д даалгахаар тогтов.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН